



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2004 оны 12 сарын 31 өдөр

Дугаар 566

Улаанбаатар хот

**Нийслэлийн өмчит байгууллагуудыг  
өөрчлөн байгуулах тухай**

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 78 дугаар зүйлийн 1, “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль”-ийн 20 дугаар зүйл, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2003 оны 128 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. “UBS телевиз”, “Баянзүрх эмнэлэг” нийслэлийн өмчит төсөвт байгууллагуудыг орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой /менежментээр хувьчлах/ үйлдвэрийн газар болгон тус тус өөрчлөн байгуулсугай.

Хоёр. Л.Балхжав ахлагчтай “UBS телевиз” багтай нийслэлийн ажил амьдралтай холбоо бүхий захиалгат нийтлэл нэвтрүүлгийн талаар гэрээ байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Ц.Болдсайхан/, Санхүү, эдийн засаг, төрийн сангийн хэлтэс /Д.Ганболд/-т, Б.Даш-Яндаг ахлагчтай багтай эмнэлэг үйлчилгээний бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулан ажиллахыг Эрүүл мэндийн газар /Ц.Ганхүү/-т тус тус даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД